



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 1118

Шивээговь сум

Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр  
сонгон шалгаруулах үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаал "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ын 6.6-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

З.Баасандалай

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүн:

Б.Базаррагчаа

(аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сум хариуцсан мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн иргэн)

Ш.Буяннэмэх

(2 дугаар багийн иргэн)

2. Суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212:0038